



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 27

Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 39 дүгээр зүйл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.6, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тус аймгийн Хушаат сумын иргэн Р.Батсуурь, Дархан-Уул аймгийн иргэн Д.Жаргалсайхан нарын Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл, гомдлыг магадлан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

М.Нямсүрэн

-Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга
Төрийн албаны зөвлөлийн салбар
зөвлөлийн гишүүн

Гишүүд:

П.Ган-Очир

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

А.Алтанцэцэг

-Аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн

2.Өргөдөл гомдлыг зохих журмын дагуу шалгаж, дүгнэлт, санал боловсруулан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2018 оны 10 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /М.Нямсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ө.СУВДАА